



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/208

Бор-Өндөр сум

**"Мотоцикл, мопедын хөдөлгөөнийг түр
хугацаагаар хориглох тухай"**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зорчих хэсгийн гадаргуу цасаар хучигдсан халтиргаа гулгаа үүсч, тээврийн хэрэгслийн зорчих хэсгийн нөхцөл байдал хүндэрсэн үед мотоцикл, мопедоор замын хөдөлгөөнд оролцогчдын эрүүл мэнд, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол эрсдэлийг багасгах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор сумын нутаг дэвсгэрт мотоцикл болон мопедоор замын хөдөлгөөнд оролцохыг 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал түр хугацаагаар хязгаарласугай.

2. Хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, ард иргэдэд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга сэрэмжлүүлэг өгч сурталчлах ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай хүргэж, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Цагдаагийн хэлтсийн дарга (цагдаагийн дэд хурандаа Т.Энхбаяр)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Галбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



АДЪЯАБИЛЭГТ